

**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

(2019 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнав)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

2019-06-17

Улаанбаатар хот

№	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр (тэрбум төгрөг)	Хүрсэн түвшин, хэрэгжилт, хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО						
Зорилт 4. Хөнгөн, хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, хүнсний эрүүл ахуйн чанарыг сайжруулна.						
4.9	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, 4, ЗГҮАХ-ийн 2.58 дахь заалт	Төрөөс худалдан бүтээгдэхүүний төрөл, тоо нэмэгдүүлэх дотоодын авалт, нэр хэмжээг	Дотоодын худалдан авалтын өсөлтийн хувь	10.0	-	<p>ТӨБЗГ – ХААХ, МТА</p> <p>Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд ХХААХҮЯ-тай хамтран “Монголд үйлдвэрлэв” 2017, 2018 оны дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний каталогийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -ийн “Цахим дэлгүүр” хэсэгт байршуулж, худалдан авах ажиллагаанд оролцогч захиалагч, нийлүүлэгчдэд сурталчлан танилцуулав.</p> <p>2019 онд ТӨБЗГ-т худалдан авах ажиллагааг нь зохион байгуулах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дотоодод үйлдвэрлэсэн, чанар,</p>

					<p>стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүн худалдан авах боломж бүхий барааны төсөл, арга хэмжээ тусгагдаагүй бөгөөд эрх шилжиж ирээгүй байна.</p> <p>Дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор үндэсний үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн, чанар, стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүнийг барилга угсралтын ажилд ашиглахаар бол бараа материал болон ажиллах хүчний хувьд дотоодын давуу эрх тооцохоор тендерийн баримт бичигт тусгасан. 2019 оны эхний хагас жилийн байдлаар, 135 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т зохион байгуулж байгаа бөгөөд тендерийн нээлт хийгдсэн 63 төсөл, арга хэмжээнээс 20 төсөл, арга хэмжээнд оролцогч 39 компанид 6.2 тэрбум төгрөгийн дотоодын давуу эрхийн зөрүүг тооцоод байна.</p> <p>Засгийн газрын 2018 оны 388 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны жагсаалт”-д тусгагдсан “Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. Ерөнхий гэрээний энэхүү худалдан авалтын хүрээнд 32 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 17 аж ахуйн нэгжтэй 47 ерөнхий гэрээ байгуулсан бөгөөд 10 (31.3%) нэр төрлийн эмийн бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчээс худалдан авч, эм, эмнэлгийн хэрэгслийн ханган нийлүүлэлтийг хийж, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжсэн байна.</p> <p><u>Өөрийн үнэлгээ:</u> “Үр дүнтэй” – 100%</p> <p><u>Тэмдэглэл:</u> Зорилт, арга хэмжээ нь шалгуур</p>
--	--	--	--	--	--

						<p>үзүүлэлт, зорилтот түвшинд хүрэх тодорхой үр дүн гарсан. Цаашид хэрэгжилт, үр дүн нэмэгдэх боломжтой. Үзүүлэлт 2018 оны мөн үеэс ахисан дүнтэй байна. 2018 оны эхний хагас жилд 21 компанид дотоодын давуу эрх олгож байсан бол 2019 оны эхний хагас жилд дотоодын давуу эрхийн зөрүү тооцуулсан компанийн тоо 18-иар нэмэгдсэн, цаашид өсөх боломжтой гэж дүгнэж байна.</p>
ТАВ. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГО						
Зорилт 18. Төрийн болон орон нутгийн өмчийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, стандарт хэмжил зүйн байгууллагын олон улсын итгэмжлэлийн үйл ажиллагааг сайжруулна.						
18.4	ЗГҮАХ-ийн 5.2.1 дэх заалт	<p>Төрийн өмчийн талаарх бодлого боловсруулан хэрэгжүүлэх, удирдлага менежментийг сайжруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, худалдан авах үйл ажиллагааг ил тод болгох, өрсөлдөх тэгш боломжоор хангах эрх зүйн орчинг боловсронгуй болгох</p>	Шинэчлэн найруулах хууль	1		<p>ТӨБЗГ – БТУХ, ХААХ, МТА</p> <p><u>1. Төрийн өмчийн асуудлаар:</u></p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг ТӨБЗГ-ын даргын 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/107 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Уг хуулийн төслийн асуудлаар ЗГХЭГ-ын холбогдох удирдлагуудтай санал солилцсон. Тус ажлын хэсэг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон үзэл баримтлалын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага, аргачлалын дагуу боловсруулан холбогдох баримт материалын хамт Ерөнхий сайд болон ЗГХЭГ-ын даргад ТӨБЗГ-ын 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А-1/1252 дугаар албан бичгээр хүргүүлэв.</p> <p>ТӨБЗГ-аас 2018 онд “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Ерөнхий сайд, Засгийн газарт 2018 оны 03 дугаар сарын 21-нд хүргүүлсэн. Тус төслийг тухайн үед Засгийн газрын</p>
			Нэмэлт, өөрчлөлт оруулах журам	1	-	

					<p>хуралдаанаар хэлэлцээд 23 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 4 хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 27 хуулийн этгээдийг хувьчлах саналыг Улсын Их Хуралд 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ЗГ-1/112 дугаар албан бичгээр өргөн барьсан. Улсын Их Хурлаас саналыг хэлэлцээд Эдийн засгийн байнгын хорооны дэргэд дэд ажлын хэсэг байгуулан дахин нарийвчлан судлахыг даалгасан. Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг эгүүлэн татах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан.</p> <p>2019 оны 4 дүгээр сард төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглалын өнөөгийн түвшин ямар байгаа, цаашид засаглалыг сайжруулах чиглэл, төрийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн удирдлага, хяналтын тогтолцоог зохистой болгох, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагыг чадавхжуулах, чиглэлээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Азийн сан, “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ-ын 2019 онд хамтран ажиллах төлөвлөгөөг баталсан. Энэ төлөвлөгөөнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалын олон улсын стандартыг судлах, төрийн өмчит компаниудад засаглалын хөндлөнгийн үнэлгээ хийх, төрийн өмчит компанийн засаглалын стандартын төсөл, төрийн өмчийн зохицуулалтын талаарх хуулийн төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, энэ чиглэлээр сургалт явуулах, төрийн өмчийн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх боловсон хүчний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх</p>
--	--	--	--	--	--

					<p>гэсэн зургаан зорилтын хүрээнд хамтран хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тусгасан. Зорилтын хүрээнд OECD олон улсын байгууллагын болон бусад олон улсын нийтлэг стандартыг орчуулж, гарын авлага болгон бэлтгэх, олон улсын жишигт нийцсэн аргачлалын дагуу төрийн өмчийн 10 хуулийн этгээдэд компанийн засаглалын үнэлгээ хийх зэрэг ажлыг эхлүүлээд байна.</p> <p>Үргүй зардлыг багасгаж, ашгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, авлага, өглөгийг бууруулах, хөрөнгө оруулалтыг оновчтой хуваарилах, үр ашигтай байх зарчмыг баримтлан төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйлдвэрлэл, санхүүгийн үр ашгийг 2018 онд дээшлүүлж, алдагдалгүй ажиллах зарчмыг баримтлан хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажилласны үр дүнд дор дурдсан ахиц өөрчлөлт гарсан (Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 93 хуулийн этгээдийн аудитаар баталгаажсан 2018 оны санхүүгийн тайланд үндэслэв):</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 93 хуулийн этгээд 2018 оны жилийн эцсийн дүнгээр 32 их наяд 489 тэрбум төгрөгийн хөрөнгө эзэмшиж, 43830 гаруй ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээр нь нийт 8 их наяд 479 тэрбум төгрөгийн орлого, 1 их наяд 290 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орлого 24.6 хувиар буюу 1 их наяд 676 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 49 хувиар буюу 424.1 тэрбум төгрөгөөр тус тус</p>
--	--	--	--	--	--

					<p>нэмэгдсэн нь эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавх сайжирсныг харуулж байна.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 82 хуулийн этгээд 2018 онд (2019 оны эхний улиралд аудитаар баталгаажсан) 1 их наяд 531 тэрбум төгрөгийн татвар, хураамжийн орлого, 42.2 тэрбум төрийн өмчийн ногдол ашиг төвлөрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 33.6 хувиар буюу 385.3 тэрбум төгрөгөөр, ногдол ашиг 3.34 дахин нэмэгдсэн дүнтэй байна (“Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөл хэрэгжүүлдэг 11 компанийн дүн ороогүй болно).</p> <p><u>2. Худалдан авах ажиллагааны талаар:</u></p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2019 оны 3 дугаар сард нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан “Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”, “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ын төслийг боловсруулах ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл ажиллаж, ажлын хэсгээс журмын төслийг боловсруулан, батлуулсан.</p> <p>Мөн “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”, “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл хөтлөх журам”-ын төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж төсөлд олон нийтээс санал авахаар төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д нээлттэй байршуулаад байна.</p> <p>Засгийн газрын 2018 оны 388 болон 2019 оны 46 дугаар тогтоолуудаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2019 онд хэрэгжүүлэх 169 төсөл, арга хэмжээнээс эхний хагас жилийн</p>
--	--	--	--	--	--

					<p>байдлаар 135 (79.8%) төсөл, арга хэмжээний зураг, төсөл болон тендер зарлахад шаардлагатай бусад материалыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсний дагуу үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажиллагааг эхлүүлээд байна. Эдгээрээс 117 төсөл, арга хэмжээний тендер зарлаж, худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр буюу төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -ээр дамжуулан зохион байгуулж байна. ТӨБЗГ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж олон нийтэд мэдээлж байна.</p> <p>ТӨБЗГ-ын эрхлэн хөтөлж байгаа төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn –д 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар, улсын дүнгээр нийт 10,000 тендер шалгаруулалтын урилга зарлагдсан дүнтэй байна. Үүнээс 9799 буюу 98.0 хувь нь “Цахим тендер шалгаруулалт”-ын урилга байна. Цахим тендер шалгаруулалтын урилга өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад, 12 хувиар буюу 3581 урилгаар нэмэгдсэн нь захиалагч байгууллагууд худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, цахим системийн хэрэглээ нэмэгдсэн, худалдан авах ажиллагааны ил тод байдалд ахиц гарсныг харуулж байна. Улсын хэмжээний уг системийн зарим тоон үзүүлэлтийн үр дүнг танилцуулбал, 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> – 1835 захиалагч байгууллагын хэрэгжүүлэх 23653 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө цахим системд бүртгэгдэж, олон нийтэд мэдээлэгдсэн; – тус системээр дамжин нийт 8328 тендер шалгаруулалтын үр дүн олон нийтэд
--	--	--	--	--	--

					<p>мэдээлэгдсэн байна. Үүнээс: нээлтийн 3140, тендер шалгаруулалтын 4947 үр дүн гарсныг мэдээлсэн бол хянан үзсэн 259, бусад үр дүнгийн 53 төлөв гарсан дүнтэй байна;</p> <ul style="list-style-type: none"> – бараа, ажил, үйлчилгээний ангиллын системд нийт 26659 бараа, ажил, үйлчилгээ бүртгэлтэй байна; – 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар, ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны үр дүнд тус системийн дэд систем болох “Цахим дэлгүүр”-ээр нийт 712 удаагийн захиалга хийгдэж, 3.9 тэрбум төгрөгийн 32 нэр төрлийн эм борлуулагдан улсын төсөвт 165.2 сая төгрөгийн хэмнэлт гарсан; – нийт 3079 гэрээ тус цахим системд бүртгэгдсэн байна. <p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn –ийн дээрх тоон үзүүлэлт бүхий мэдээлэл уг системд нээлттэй мэдээлэгдэж, худалдан авах ажиллагааны ил тод байдал хангагдаж байна.</p> <p><u>Өөрийн үнэлгээ:</u> “Үр дүнтэй” – 100%</p> <p><u>Тэмдэглэл:</u> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрэх тодорхой ажил хийгдсэн, зарим үр дүн гарсан. Цаашид хэрэгжилт, үр дүн нэмэгдэх боломжтой. Үзүүлэлт 2018 оны мөн үеэс ахисан дүнтэй байна.</p>
--	--	--	--	--	--

Үнэлгээний дүнгийн танилцуулга:

Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний тоо – **2 (ТӨБЗГ-ын дангаар хэрэгжүүлэх 1, хамтран хэрэгжүүлэх 1 заалт)** байна.
Үүнээс:

- “Үр дүнтэй” буюу 100 хувь - 2 зорилт, арга хэмжээ;
- Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ (хувь) – **100.0 хувь буюу “Үр дүнтэй”**.

ТАНИЛЦСАН:
ДЭД ДАРГА

А.ДАГВАДОРЖ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

ТАЙЛАНГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ